


|                                         |    |
|-----------------------------------------|----|
| Зурган индекс .....                     | 3  |
| Хайбрид систем                          |    |
| Хайбрид .....                           | 19 |
| Автомашинаас бууж суух                  |    |
| Түлхүүр.....                            | 22 |
| Smart Entry & Start систем .....        | 24 |
| Жолоодлогын үед                         |    |
| Асаах товч .....                        | 25 |
| EV жолоодлогын горим .....              | 28 |
| Автомат хурдны хайрцаг .....            | 29 |
| Хайбрид хурдны хайрцаг .....            | 32 |
| Эргэх дохионы хөшүүрэг.....             | 35 |
| Зогсоолын тоормос .....                 | 36 |
| Тоормос баригч.....                     | 38 |
| Мэдээллийн дэлгэц .....                 | 39 |
| Дэлгэцээр гарах мэдээллийн агуулга..... | 40 |
| Их гэрлийн асаагуур .....               | 44 |
| AHS холын гэрэл .....                   | 46 |
| AHB холын гэрэл .....                   | 48 |
| Манангийн гэрлийн товч .....            | 50 |
| Салхины шил арчигч, угаагч.....         | 52 |
| Хойд шил арчигч, угаагч .....           | 54 |
| Жолоодлогын горим сонгох товч.....      | 55 |

|                                                 |    |
|-------------------------------------------------|----|
| Жолоодлогын тав тух                             |    |
| Ухаалаг утас ба бусад төхөөрөмж холбох .....    | 57 |
| Агааржуулалтын автомат горим .....              | 64 |
| Урд автомат агааржуулалтын систем .....         | 65 |
| Арын агааржуулалтын систем.....                 | 67 |
| Нээх ба хаах                                    |    |
| Хажуу хаалга .....                              | 69 |
| Автомат цонх .....                              | 71 |
| Дээврийн нээлхий .....                          | 72 |
| Панорамик дээврийн нээлхий .....                | 73 |
| Шатахууны савны таг .....                       | 75 |
| Тээшний автомат хаалга.....                     | 76 |
| Энэ үед яах вэ...                               |    |
| Анхааруулах гэрэл, индикаторын жагсаалт .....   | 82 |
| Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед .....    | 86 |
| Хайбрид систем асахгүй үед .....                | 88 |
| Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед ..... | 89 |

## ■ Хянах самбар (зүүн жолооны хүрдтэй автомашин)



|          |                                                                    |          |
|----------|--------------------------------------------------------------------|----------|
| <b>A</b> | Асаах товч .....                                                   | P.25     |
|          | Хайбрид систем асаах/товчны горим солих .....                      | P.25     |
|          | Онцгой нөхцөлд хайбрид систем унтраах .....                        | P.27     |
|          | Хайбрид систем асахгүй үед .....                                   | P.88     |
|          | Анхааруулга* <sup>1</sup>                                          |          |
| <b>B</b> | Арааны хөшүүрэг .....                                              | P.29, 32 |
|          | Арааны хөшүүрэг сэлгэх .....                                       | P.29, 32 |
|          | Чиргүүл чирэх үеийн анхааруулга* <sup>1</sup>                      |          |
| <b>C</b> | Хэмжих хэрэгслүүд* <sup>1</sup>                                    |          |
|          | Хянах самбарын заалт унших/гэрлийн түвшин тохируулах* <sup>1</sup> |          |
|          | Анхааруулах гэрэл/индикатор .....                                  | P.82     |
|          | Анхааруулах гэрэл ассан үед* <sup>1</sup>                          |          |
| <b>D</b> | Мэдээллийн дэлгэц .....                                            | P.39     |
|          | Дэлгэц .....                                                       | P.39     |
|          | Энергийн монитор .....                                             | P.42     |
|          | Дэлгэц дээр анхааруулга гарсан үед* <sup>1</sup>                   |          |


|          |                                                                                                                       |          |
|----------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|
| <b>E</b> | Эргэх дохионы хөшүүрэг.....                                                                                           | P.35     |
|          | Их гэрлийн асаагуур.....                                                                                              | P.44     |
|          | Их гэрэл/урд оврын гэрэл/арын гэрэл/хойд хажуугийн оврын гэрэл/<br>улсын дугаарын гэрэл/өдрийн хөдөлгөөний гэрэл..... | P.44     |
|          | Урд манангийн гэрэл/хойд манангийн гэрэл* <sup>2</sup> .....                                                          | P.50     |
| <b>F</b> | Салхины шил арчигч, угаагчийн товч .....                                                                              | P.52, 54 |
|          | Ашиглалт.....                                                                                                         | P.52, 54 |
|          | Шил арчигчийн шингэн нэмэх* <sup>1</sup>                                                                              |          |
|          | Анхааруулга* <sup>1</sup>                                                                                             |          |
| <b>G</b> | Ослын дохионы гэрлийн товч* <sup>1</sup>                                                                              |          |
| <b>H</b> | Капот нээх хөшүүрэг* <sup>1</sup>                                                                                     |          |
| <b>I</b> | Жолооны хүрд тохируулах товч* <sup>1</sup>                                                                            |          |
|          | Тохиргоо* <sup>1</sup>                                                                                                |          |
|          | Жолоодлогын байрлал санах ой* <sup>1, 2</sup>                                                                         |          |
| <b>J</b> | Агааржуулалтын систем .....                                                                                           | P.65, 67 |
|          | Ашиглалт.....                                                                                                         | P.65, 67 |
|          | Хойд цонхны цан арилгагч* <sup>1</sup>                                                                                |          |
| <b>K</b> | Аудио систем* <sup>3</sup>                                                                                            |          |

\*1: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

\*2: Тоноглогдсон автомашинд

\*3: "Мултимедиа гарын авлага"-г харна уу.

## ■ Товч (зүүн жолооны хүрдтэй автомашин)



**A** “ODO TRIP” товч\*<sup>1</sup>

**B** Хянах самбарын гэрлийн удирдлагын товч\*<sup>1</sup>

**C** Advanced Park (зогсоолд байрлуулахад туслах систем)-н үндсэн товч\*<sup>1, 2</sup>

**D** Камерын товч\*<sup>2, 3</sup>

**E** Тээшний автомат хаалганы товч ..... P.76


**F** Шатахууны савны таг нээх товч ..... P.75

**G** Жолоодлогын байрлал санах ойн товч\*<sup>1, 2</sup>

\*<sup>1</sup>: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.


\*<sup>2</sup>: Тоноглогдсон автомашинд

\*<sup>3</sup>: "Мултимедиа гарын авлага"-г харна уу.



- A** Хажуугийн толины товч\*
- B** Хаалга түгжих товч ..... P.69
- C** Автомат цонхны товч..... P.71
- D** Цонх түгжих товч ..... P.71


\*: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.



- A** Жолооны хурдний арааны нэмэлт хөшүүрэг ..... P.30, 33
- B** Хянах самбарын удирдлагын товч ..... P.40
- C** Хурд баригчийн товч  
Динамик радарын хурд баригч\*1, 2  
Хурд баригч\*1
- D** Жолооны хурдний удирдлагын товч..... P.57
- E** LTA системийн товч\*1, 2
- F** Гар утасны товч ..... P.57
- G** Дуудлага хийх, яриаг дуусгах товч ..... P.57
- H** Жолооны хурдний удирдлагын товч/Гар утасны товч/Дуудлага хийх,  
яриаг дуусгах товч ..... P.57
- I** Товчны ажиллагаа солих товч ..... P.40

\*1: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

\*2: Тоноглогдсон автомашинд




- A** Р арааны товч ..... P.29, 32
- B** Тоормос баригчийн товч ..... P.38
- C** EV жолоодлогын горимын товч\*<sup>1</sup> ..... P.28
- D** Trail горимын товч\*<sup>1, 2</sup>
- E** Зогсоолын тоормосны товч..... P.36  
 Залгах/салгах..... P.36  
 Өвлийн улирлын үеийн анхааруулга\*<sup>2</sup>  
 Анхааруулах дуу/анхааруулга\*<sup>2</sup>
- F** VSC OFF товч\*<sup>2</sup>

\*1: Тоноглогдсон автомашинд

\*2: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

## ■ Дотор тал (зүүн жолооны хүрдтэй автомашин)



**A** Толгойн түшлэг\*

**B** Туслах бариул\*

**C** Аюулгүйн бүс\*

**D** SRS аюулгүйн дэр\*

**E** Шалавч\*

**F** Аяганы тавиур\*


**G** Голын хайрцаг\*

**H** Урд суудал\*

**I** Арын суудал\*

\*: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

## ■ Дээд тал (зүүн жолооны хүрдтэй автомашин)




- A** Салоны гэрэл\*<sup>1</sup>  
Хувийн гэрлүүд\*<sup>1, 2</sup>
- B** Дээврийн нээлхийн товч\*<sup>3</sup> ..... P.72  
Панорамик дээврийн нээлхийн товч\*<sup>3</sup> ..... P.73
- C** Хаалгатай холбоотой салоны гэрлийн товч\*<sup>1</sup>
- D** “SOS” товч\*<sup>1, 3</sup>
- E** Туслах хайрцаг\*<sup>1</sup>
- F** Гоо сайхны толь\*<sup>1</sup>
- G** Нарны хаалт\*<sup>1</sup>
- H** Голын толь\*<sup>1, 3</sup>  
Дижитал голын толь\*<sup>1, 3</sup>
- I** Гаражны хаалга нээгчийн товч\*<sup>1, 3</sup>

\*<sup>1</sup>: “Хэрэглэгчийн гарын авлага”-г харна уу.

\*<sup>2</sup>: Зурагт урд талыг үзүүлсэн ба хойд тал мөн тоноглогдсон.

\*<sup>3</sup>: Тоноглогдсон автомашинд

## ■ Хянах самбар (баруун жолооны хүрдтэй автомашин)



- A** Асаах товч ..... P.25
  - Хайбрид систем асаах/товчны горим солих ..... P.25
  - Онцгой нөхцөлд хайбрид систем унтраах ..... P.27
  - Хайбрид систем асахгүй үед ..... P.88
  - Анхааруулга\*<sup>1</sup>
- B** Арааны хөшүүрэг ..... P.29, 32
  - Арааны хөшүүрэг сэлгэх ..... P.29, 32
  - Чиргүүл чирэх үеийн анхааруулга\*<sup>1</sup>
- C** Хэмжих хэрэгслүүд\*<sup>1</sup>
  - Хянах самбарын заалт унших/гэрлийн түвшин тохируулах\*<sup>1</sup>
  - Анхааруулах гэрэл/индикатор ..... P.82
  - Анхааруулах гэрэл ассан үед\*<sup>1</sup>
- D** Мэдээллийн дэлгэц ..... P.39
  - Дэлгэц ..... P.39
  - Энергийн монитор ..... P.42
  - Дэлгэц дээр анхааруулга гарсан үед\*<sup>1</sup>


|          |                                                                                                                       |          |
|----------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|
| <b>E</b> | Эргэх дохионы хөшүүрэг.....                                                                                           | P.35     |
|          | Их гэрлийн асаагуур.....                                                                                              | P.44     |
|          | Их гэрэл/урд оврын гэрэл/арын гэрэл/хойд хажуугийн оврын гэрэл/<br>улсын дугаарын гэрэл/өдрийн хөдөлгөөний гэрэл..... | P.44     |
|          | Урд манангийн гэрэл/хойд манангийн гэрэл* <sup>2</sup> .....                                                          | P.50     |
| <b>F</b> | Салхины шил арчигч, угаагчийн товч .....                                                                              | P.52, 54 |
|          | Ашиглалт.....                                                                                                         | P.52, 54 |
|          | Шил арчигчийн шингэн нэмэх* <sup>1</sup>                                                                              |          |
|          | Анхааруулга* <sup>1</sup>                                                                                             |          |
| <b>G</b> | Ослын дохионы гэрлийн товч* <sup>1</sup>                                                                              |          |
| <b>H</b> | Капот нээх хөшүүрэг* <sup>1</sup>                                                                                     |          |
| <b>I</b> | Жолооны хүрд тохируулах товч* <sup>1</sup>                                                                            |          |
|          | Тохиргоо* <sup>1</sup>                                                                                                |          |
|          | Жолоодлогын байрлал санах ой* <sup>1, 2</sup>                                                                         |          |
| <b>J</b> | Агааржуулалтын систем .....                                                                                           | P.65, 67 |
|          | Ашиглалт.....                                                                                                         | P.65, 67 |
|          | Хойд цонхны цан арилгагч* <sup>1</sup>                                                                                |          |
| <b>K</b> | Аудио систем* <sup>3</sup>                                                                                            |          |

\*1: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

\*2: Тоноглогдсон автомашинд

\*3: "Мултимедиа гарын авлага"-г харна уу.

## ■Товч (баруун жолооны хүрдтэй автомашин)



**A** Камерын товч\*<sup>1</sup>

**B** Advanced Park (зогсоолд байрлуулахад туслах систем)-н үндсэн товч\*<sup>2, 3</sup>

**C** Хянах самбарын гэрлийн удирдлагын товч\*<sup>3</sup>

**D** “ODO TRIP” товч\*<sup>3</sup>

**E** Жолоодлогын байрлал санах ойн товч\*<sup>2, 3</sup>


**F** Тээшний автомат хаалганы товч ..... P.76

**G** Шатахууны савны таг нээх товч ..... P.75

\*<sup>1</sup>: "Мултимедиа гарын авлага"-г харна уу.


\*<sup>2</sup>: Тоноглогдсон автомашинд

\*<sup>3</sup>: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.




- A** Хажуугийн толины товч\*
- B** Хаалга түгжих товч ..... P.69
- C** Автомат цонхны товч..... P.71
- D** Цонх түгжих товч ..... P.71

\*: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.



- A** Жолооны хурдний арааны нэмэлт хөшүүрэг ..... P.30, 33
- B** Хянах самбарын удирдлагын товч ..... P.40
- C** Хурд баригчийн товч  
Динамик радарын хурд баригч\*  
Хурд баригч\*
- D** Жолооны хурдний удирдлагын товч..... P.57
- E** LTA системийн товч\*
- F** Гар утасны товч ..... P.57
- G** Дуудлага хийх, яриаг дуусгах товч ..... P.57
- H** Жолооны хурдний удирдлагын товч/Гар утасны товч/  
Дуудлага хийх, яриаг дуусгах товч ..... P.57
- I** Товчны ажиллагаа солих товч ..... P.40

\*: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.




- A** Р арааны товч ..... P.29, 32
- B** Тоормос баригчийн товч ..... P.38
- C** VSC OFF товч<sup>\*1</sup>
- D** Trail Mode товч<sup>\*1, 2</sup>
- E** Зогсоолын тоормосны товч..... P.36  
 Залгах/салгах..... P.36  
 Өвлийн улирлын үеийн анхааруулга<sup>\*1</sup>  
 Анхааруулах дуу/анхааруулга<sup>\*1</sup>
- F** EV жолоодлогын горимын товч<sup>\*2</sup> ..... P.28

<sup>\*1</sup>: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

<sup>\*2</sup>: Тоноглогдсон автомашинд

## ■ Дотор тал (баруун жолооны хүрдтэй автомашин)



**A** Толгойн түшлэг\*

**B** Туслах бариул\*

**C** Аюулгүйн бүс\*

**D** SRS аюулгүйн дэр\*

**E** Шалавч\*

**F** Аяганы тавиур\*


**G** Голын хайрцаг\*

**H** Урд суудал\*

**I** Арын суудал\*

\*: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

## ■ Дээд тал (баруун жолооны хүрдтэй автомашин)



**A** Салоны гэрэл\*1

Хувийн гэрлүүд\*1, 2

**B** Дээврийн нээлхийн товч\*3 ..... P.72

Панорамик дээврийн нээлхийн товч\*3 ..... P.73

**C** Хаалгатай холбоотой салоны гэрлийн товч\*1

**D** Туслах хайрцаг\*1

**E** Голын толь\*1, 3

Дижитал голын толь\*1, 3

**F** Нарны хаалт\*1

**G** Гоо сайхны толь\*1

\*1: "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

\*2: Зурагт урд талыг үзүүлсэн ба хойд тал мөн тоноглогдсон.

\*3: Тоноглогдсон автомашинд


## Хайбрид систем

Тус автомашин нь хайбрид цахилгаан автомашин бөгөөд энгийн хөдөлгүүртэй автомашинаас өөр онцлогтой. Өөрийн автомашины онцлогтой танилцаж, анхаарал болгоомжтой ашиглана уу.

Хайбрид систем нь бензин хөдөлгүүр, цахилгаан мотор (хөтлөх мотор)-с бүрдэх ба жолоодлогод нийцүүлэн шатахуун зарцуулалтыг сайжруулж хаягдал утааг бууруулдаг.

Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-г харна уу.

## Хайбрид системийн индикатор



Зураг нь жишээ бөгөөд техник үзүүлэлтээс хамаарч өөр байж болно.

### **A** Цэнэглэх бүс

Цэнэг дахин сэргээх\* ажиллагааг харуулна.

### **B** Эко бүс

Автомашин байгаль орчинд ээлтэй байдлаар явж буйг илтгэнэ.

### **C** Хүчний бүс

Байгаль орчинд ээлтэй жолоодлогын бүсээс гарсныг илтгэнэ (бүх хүчээр явах зэрэг).

### **D** Хайбрид эко бүс

Бензин хөдөлгүүрийн хүч бага ашиглагдаж буйг илтгэнэ.

Тухайн нөхцөлөөс хамаарч хөдөлгүүр автоматаар асаж унтарна.

- Индикаторын зүүг эко бүсэд барьж байгаль орчинд ээлтэй жолоодлого хийх боломжтой.

- Цэнэглэх бүс нь цэнэг дахин сэргээх\* ажиллагааг харуулна. Тус энергизр хайбрид батарей (хөтлөх батарей) цэнэглэнэ.

\*: Тус гарын авлагад дахин сэргээх гэдэг нь автомашины хөдөлгөөнөөс

## **Автомашин анхааруулах акустик систем (тоноглогдсон автомашинд)**

Бензин хөдөлгүүр унтарсан үед хурдад нийцүүлэн дуу гаргаж автомашин ойртож буйг ойр орчмын хүмүүст анхааруулна. Тус дуу нь бүхээг дотор мөн сонсогдож болно. Хурд 25км/ц (15 миль/ц)-с давах үед дуу зогсоно.

## **Хайбрид батарей (хөтлөх батарей) цэнэглэх (RX350h)**

Арааны N байрлалд хайбрид батарей (хөтлөх батарей) цэнэглэгдэхгүй. Батарейн цэнэг суухаас сэргийлж N араатай удаан орхихоос зайлсхийнэ.

## **Цэнэг дахин сэргээх тоормос**

Дараах нөхцөлүүдэд кинетик энерги цахилгаан энерги болон хувирах ба хайбрид батарей (хөтлөх батарей) цэнэглэх замаар хурд хасна.

- RX350h: D эсвэл S араатай явах үед хааз сулласан.
- RX500h: D эсвэл M араатай явах үед хааз сулласан.
- RX350h: D эсвэл S араатай явах үед тоормос гишгэсэн.
- RX500h: D эсвэл M араатай явах үед тоормос гишгэсэн.

## **Хайбрид цахилгааны автомашины дуу чимээ**

Хөдөлгүүрийн дуу, чичиргээ гардаггүй учир хайбрид электрон автомашин асаалттай ба “READY” индикатор асаж байгаа үед ч унтраастай гэж андуурагддаг. Аюулгүйн үүднээс зогссон үед арааг P-д шилжүүлж зогсоолын тоормос идэвхжүүлнэ.


Хайбрид системийн дараах дуу, чичиргээ нь доголдлыг илэрхийлэхгүй:

- Хөдөлгүүрийн хэсгээс моторын дуу гарч болно.
- Хайбрид систем асах, унтрах үед арын суудлын доор байрлах хайбрид батарей (хөтлөх батарей)-с дуу гарч болно.
- Хайбрид систем асах, унтрах үед арын суудлын доор байрлах хайбрид батарей (хөтлөх батарей)-с релей ажиллах тас хийх дуу гарч болно.
- Тээшний хаалга онгорхой үед хайбрид системийн дуу сонсогдож болно.
- Бензин хөдөлгүүр асах болон унтрах, бага хурдаар явах эсвэл хөдөлгүүр нормал хаазаар ажиллах үед хурдны хайрцагнаас дуу гарч болно.
- Огцом хурд нэмэх үед хөдөлгүүрийн дуу сонсогдож болно.
- Тоормослох, хааз суллах үед цэнэг дахин сэргээх тоормосны дуу гарч болно.
- Бензин хөдөлгүүр асах болон унтрах үед чичиргээ мэдрэгдэж болно.
- Арын суудлын доод талд байрлах хөргөлтийн сэнс дуугарч болно.

## Шатахуун дуусах

Шатахуун дуусаж хайбрид систем асахгүй үед хамгийн багадаа шатахууны түвшин багассаныг анхааруулах гэрэл унтрах хэмжээний шатахуунаар цэнэглэнэ. Шатахууны хэмжээ бага үед хайбрид систем асахгүй байж болно. Автомашин тэгш газар зогссон үеийн шатахууны стандарт хэмжээ 9.8л [2.6 gal., 2.2 Imp. gal.] байдаг. Автомашин налуу газар зогссон үед тус хэмжээ өөр байж болно. Автомашин хазайсан үед шатахуун нэмэлтээр хийнэ.)

## Хайбрид системийн анхааруулах мэдээлэл




Хайбрид системд доголдол үүссэн эсвэл буруу ажиллуулах оролдлого хийсэн үед дэлгэц дээр анхааруулах мэдээлэл автоматаар гардаг.

Мэдээллийн дэлгэц дээр анхааруулах мэдээлэл гарсан үед анхааралтай уншиж зааварчилгааг дагана.

# Түлхүүр

## Түлхүүр



### A Электрон түлхүүр

- Smart Entry & Start систем ажиллуулна
- Түлхүүрийн алсын удирдлага ажиллуулна


### B Механик түлхүүр

### C Түлхүүрийн дугаар бүхий пайз

### D Түлхүүр карт (электрон түлхүүр) (тоноглогдсон автомашинд)

Smart Entry & Start систем ажиллуулна

## Түлхүүрийн алсын удирдлага



### A Бүх хаалга түгжинэ

### B БНСУ-с бусад: Цонх\*<sup>2</sup> ба дээврийн нээлхий\*<sup>1, 2</sup> эсвэл панорамик дээврийн нээлхий\*<sup>1, 2</sup> хаана

### C Бүх хаалга тайлна


### D БНСУ-с бусад: Цонх\*<sup>2</sup> ба дээврийн нээлхий\*<sup>1, 2</sup> эсвэл панорамик дээврийн нээлхий\*<sup>1, 2</sup> нээнэ

### E Тээшний хаалга нээж хаана

### F Дохиолол дуугаргана\*<sup>1</sup>

\*<sup>1</sup>: Тоноглогдсон автомашинд

\*<sup>2</sup>: Эдгээр тохиргоог та Lexus дилер дээрээ хийлгэх шаардлагатай.



Түгжээ тайлах товчийг дарж механик түлхүүрийг сугалан гаргана.

Механик түлхүүрийг зөвхөн нэг тийш харуулан хийх боломжтой ховил электрон түлхүүрт байдаг. Түлхүүрийн нүхэнд механик түлхүүр орохгүй үед механик түлхүүрийг нөгөө тийш нь харуулан хийнэ.


Механик түлхүүрийг хэрэглэсний дараа электрон түлхүүрт буцаан хийж хадгалах ба электрон түлхүүрээс салгаж болохгүй. Электрон түлхүүрний зай суусан эсвэл entry функцийг хэвийн ажиллагаа алдагдсан үед танд механик түлхүүр хэрэг болно.

## Smart Entry & Start систем

Автомашины электрон түлхүүрийг (түлхүүр карт мөн хамаарна) биедээ авч яваа үедээ дараах үйлдлүүдийг хийх боломжтой. Жолооч электрон түлхүүрийг байнга биедээ авч явна.

Хайбрид систем асаах тухай дэлгэрэнгүйг 25-р хуудаснаас харна уу.

### Гадна талаас хаалга түгжих, тайлах



- 1 Хаалганы бариулыг атгаж бүх хаалганы түгжээ тайлна.\*

Зарим загварт: Жолоочийн хаалганы бариулыг атгаж тус хаалганы түгжээ тайлна. Зорчигчийн хаалганы бариулыг атгаж бүх хаалганы түгжээг тайлна.\*


Хаалганы бариулын ард байрлах мэдрэгчид хүрээгүй тохиолдолд түгжээ тайлагдахгүй.

Хаалга түгжигдсэнээс хойш 3 секундэд түгжээ тайлагдахгүй.

\*: Түгжээ тайлах тохиргоог өөрчилж болно.

- 2 Түгжих сенсор (баруулын хонхорхой хэсэг)-т хүрч хаалгыг түгжинэ. Хаалга бүрэн түгжигдсэн эсэхийг шалгана.

### Тээшний хаалга гадна талаас түгжих, тайлах



- 1 Бүх хаалга түгжинэ.

Хаалга бүрэн түгжигдсэн эсэхийг шалгана.

- 2 Бүх хаалга тайлна.

Хаалга түгжигдсэнээс хойш 3 секундийн хугацаанд түгжээ тайлагдахгүй.

Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед 86-р хуудсыг харна уу.

## Асаах товч

Электрон түлхүүр биедээ авч яваа үед дараах дарааллаар хайбрид систем асаах, асаах товчны горим солих боломжтой.

### Хайбрид систем асаах

- 1 Зогсоолын тоормосны товчийг татаж тоормос залгагдсан эсэхийг нягтална.

Зогсоолын тоормосны индикатор асна.

- 2 Тоормосны дөрөөг гүйцэд гишгэнэ.

Мэдээллийн дэлгэц дээр  тэмдэг болон анхааруулга гарна.

Тэмдэг, анхааруулга гараагүй үед хайбрид систем асахгүй.

Арааны N байрлалд хайбрид систем асахгүй.

Хайбрид систем асаах үед арааг P-д шилжүүлнэ.



- 3 Асаах товчийг богино, чанга дарна.

Асаах товчийг нэг удаа чанга дараад авахад хангалттай ба удаан дарах шаардлагагүй.

“READY” индикатор ассан үед хайбрид систем хэвийн ажиллана.

“READY” индикатор асах хүртэл тоормосны дөрөөг үргэлжлүүлэн гишгэнэ.

Асаах товчны бүх горимоос хайбрид систем асаах боломжтой.

- 4 “READY” индикатор ассаныг нягтална.


“READY” индикатор асаагүй үед автомашин хөдлөхгүй.

## Хайбрид систем унтраах

- 1 Автомашиныг зогсооно.
- 2 Зогсоолын тоормос залгана.
- 3 Р арааны товч дарна.  
Арааны Р байрлалын индикатор болон зогсоолын тоормосны индикатор ассан байгааг нягтална.
- 4 Асаах товч дарна.  
Хайбрид системийн ажиллагаа зогсож хянах самбарын заалтууд унтарна (хянах самбар унтарснаас хэдэн секундйн дараа арааны байрлалын индикатор унтарна).
- 5 Тоормосны дөрөөг суллах ба мэдээллийн дэлгэц дээр ACC эсвэл ON гараагүйг нягтална.

## Асаах товчны горим солих

Асаах товчны горимыг тоормосны дөрөө гишгээгүй үед асаах товчийг даран солих боломжтой. (Товч дарах тухай бүрт горим солигдоно.)




- 1 Off  
Ослын дохионы гэрэл ашиглах боломжтой.
  - 2 ACC\*  
Аудио систем зэрэг зарим электрон төхөөрөмжийг ашиглах боломжтой.
  - 3 ON  
Бүх электрон төхөөрөмжийг ашиглах боломжтой.
- \*: Өөрчлөх боломжтой тохиргооны цэс дээр ACC горимыг идэвхжүүлэх/цуцлах боломжтой.

## Онцгой нөхцөлд автомашиныг зогсоох шаардлагатай үед

Автомашиныг хэвийн байдлаар зогсоох боломжгүй болсон зэрэг зөвхөн онцгой, аваарын нөхцөл үүссэн үед дараах дарааллаар зогсооно:

- 1 Тоормосны дөрөөг 2 хөлөөрөө чанга үргэлжлүүлэн гишгэнэ.  
Автомашиныг зогсооход шаардагдах тоормосны барилт буурах тул тоормосны дөрөөг олон дахин гишгэж болохгүй.
- 2 Арааг N байрлалд шилжүүлнэ.  
► Араа N байрлалд шилжсэн үед
- 3 Хурд буурсны дараа замын хажууд аюулгүй газар зогсооно.
- 4 Хайбрид систем унтраана.  
► Арааг N байрлалд шилжүүлж болохгүй үед
- 3 Автомашины хурдыг боломжит хэмжээнд хамгийн ихээр бууруулахын тулд тоормосны дөрөөг 2 хөлөөрөө үргэлжлүүлэн гишгэнэ.




- 4 асаах товчийг 2 ба түүнээс дээш секунд үргэлжлүүлэн дарах эсвэл 3 ба түүнээс олон удаа богино хугацаанд товчийг дарж хайбрид системийг унтраана.

- 5 Замын хажууд аюулгүй газар зогсооно.

## EV жолоодлогын горим (RX350h)

EV жолоодлогын горимд хайбрид батарей (хөтлөх батарей)-н цахилгаан болон зөвхөн цахилгаан мотор (хөтлөх мотор)-н хүчээр автомашин явна.

Тус горим нь орон сууцны хорооллоор өглөө эрт болон шөнийн цагаар мөн битүү авто зогсоол дотор дуу чимээ, хаягдал утаанд санаа зовох зүйлгүйгээр явах боломжийг олгодог.




EV жолоодлогын горим асаах/унтраах

EV жолоодлогын горим ассан үед EV жолоодлогын горимын индикатор асна. Товч EV жолоодлогын горимд байгаа үед дахин дарсан нөхцөлд товчны горим хэвийн жолоодлогын горимд (бензин хөдөлгүүр болон цахилгаан мотор [хөтлөх мотор]) шилжинэ.

## Автомат хурдны хайрцаг (RX500h)

### Арааны байрлалын дэлгэц ба араа шилжүүлэх



#### **A** Арааны хөшүүрэг

Арааны байрлалын индикаторын сумны чиглэлийн дагуу арааны хөшүүргийг зөөлөн шилжүүлнэ.

N араанд шилжүүлэх үед арааны хөшүүргийг сумны чиглэлийн дагуу түлхээд барина.

Араа шилжүүлэх үйлдэл дууссаны дараа арааны хөшүүргийг анхны ( ● ) байрлалд буцаана.

Зөвхөн D байрлалаас M арааны байрлалд шилжүүлэх боломжтой.

P-с N, D, R араанд, N, D, M, R-с P араанд, D, M-с R араанд эсвэл R-с D араанд шилжүүлэх үед тоормос гишгэн автомашин бүрэн зогсоосон байна.

#### **B** Арааны байрлалын индикатор

Хянах самбарын дэлгэц:

Одоогийн арааны байрлал асна.

Арааны хөшүүргийн дэлгэц:

Одоогийн арааны байрлал асна.

Арааны байрлал сонгох үед хянах самбар болон арааны хөшүүргийн дэлгэц дээр тухайн сонгох арааны индикатор ассан байгаа эсэхийг нягтална.

#### **C** P арааны товч

Автомашин бүрэн зогссоны дараа зогсоолын тоормосыг залгаж P арааны товч дарна.

Араа P байрлалд шилжсэн үед товч дээрх гэрэл асна.

Арааны байрлалын индикатор P-г зааж байгаа эсэхийг нягтална.

## Арааны байрлалын зориулалт ба функц

| Арааны байрлал | Зориулалт ба функц                       |
|----------------|------------------------------------------|
| P              | Зогсоолд байрлуулах/хайбрид систем асаах |
| R              | Ухрах                                    |
| N              | Сул араа (Хүч дамжихгүй араа)            |
| D              | Хэвийн жолоодлого*1                      |
| M              | M жолоодлогын горим*2                    |

\*1: Шатахуун зарцуулалтыг сайжруулах, дуу чимээг бууруулах үүднээс хэвийн жолоодлогын үед D арааны байрлалыг сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ашиглан жолоодлого солигдох дээд арааг сонгох боломжтой.

\*2: M горимоор жолоодох үед солигдох дээд арааг сонгох боломжтой.

## Жолоодлогын горим сонгох

### Жолоодлогын горим


→P. 55

## D араанд солигдох дээд арааг сонгох

Арааг түр өөрчлөн жолоодох үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн “-” эсвэл “+” талыг дарна.

Нэмэлт хөшүүргийн “-” товч дарах үед жолоодлогод нийцсэн хөдөлгүүрийн тоормос гаргах боломжтой дээд араанд шилжинэ. “+” товч дарж илүү хөнгөн араа хүртэл араа солих хязгаарыг нэмэгдүүлнэ.

Шаардлагагүй хөнгөн араанд шилжихээс сэргийлж араа сольсноор хөнгөн арааг хязгаарлаж, хөдөлгүүрийн тоормос үүсгэдэг.



1 Хөнгөн араанд шилжүүлэх

2 Хүнд араанд шилжүүлэх

Хянах самбар дээр тухайн сонгосон D1-с D6 хүртэлх солигдох боломжтой арааны дээд хязгаарыг харуулна.

Хэвийн жолоодлогын D байрлалд буцаах үед “+” товчийг доош тодорхой хугацаанд дарах шаардлагатай.


## ■ Араа шилжих хязгаар ба тэдгээрийн функц

| Хянах самбарын дэлгэц | Функц                                                                                                                        |
|-----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| D2 - D6               | Автомашины хурд болон жолоодлогын байдлаас хамаарч 1-р араанаас тухайн сонгосон араа хүртэлх араанууд автоматаар сонгогдоно. |
| D1                    | 1-р араа сонгогдоно                                                                                                          |

Хөнгөн араанаас хүнд араа нь илүү хүчтэй хөдөлгүүрийн тоормосны хүч үүсгэнэ.

## М горимд араа сонгох

Арааны хөшүүргийг М байрлалд сэлгэж М горимыг сонгоно. Жолооны хурдний арааны нэмэлт хөшүүргийг хөдөлгөж жолоодох арааг сонгоно.



**1** Хөнгөн араанд шилжүүлэх

**2** Хүнд араанд шилжүүлэх

Жолооны хурдний арааны нэмэлт хөшүүрэг хөдөлгөх бүрт араа нэгээр солигдоно.

M1-с M6 хүртэлх сонгосон араанд түгжигдэж тухайн араа дэлгэц дээр гарна.


М арааны байрлалд жолооны хурдний арааны нэмэлт хөшүүргийг хөдөлгөөгүй үед араа шилжихгүй. Мөн автомашины хурд бага үед хөнгөн араанд шилжүүлэх үйлдэл хийсэн ч араа солигдохгүй.

Нөгөөтээгүүр М араатай байсан ч дараах нөхцөлүүдэд араа автоматаар солигдоно:

- Автомашины хурд буурах үед (зөвхөн хүнд араанд).
- Автомашины хурд нэмэгдэх үед (зөвхөн хөнгөн араанд).
- Хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн.
- Хурдны хайрцагны шингэний хэм хэт бага, хэт өндөр үед хурдны хайрцгийг хамгаалах үүднээс мөн бусад шалтгаанаар.

# Хайбрид хурдны хайрцаг (RX350h)

## Арааны байрлалын дэлгэц ба араа шилжүүлэх



### **A** Арааны хөшүүрэг

Арааны байрлалын индикаторын сумны чиглэлийн дагуу арааны хөшүүргийг зөөлөн шилжүүлнэ.

N араанд шилжүүлэх үед арааны хөшүүргийг сумны чиглэлийн дагуу түлхээд барина.

Араа шилжүүлэх үйлдэл дууссаны дараа арааны хөшүүргийг анхны (●) байрлалд буцаана.

Зөвхөн D байрлалаас S арааны байрлалд шилжүүлэх боломжтой.

P-с N, D, R араанд, N, D, S, R-с P араанд, D, S-с R араанд эсвэл R-с D араанд шилжүүлэх үед тоормос гишгэн автомашиныг бүрэн зогсоосон байна.

### **B** Арааны байрлалын индикатор

Хянах самбарын дэлгэц:

Одоогийн арааны байрлал асна.

Арааны хөшүүргийн дэлгэц:

Одоогийн арааны байрлал асна.

Арааны байрлал сонгох үед хянах самбар болон арааны хөшүүргийн дэлгэц дээр тухайн сонгох арааны индикатор ассан байгааг нягтална.

### **C** P арааны товч

Автомашин бүрэн зогссоны дараа зогсоолын тоормосыг залгаж P арааны товч дарна.

Араа P байрлалд шилжсэн үед товч дээрх гэрэл асна.

Арааны байрлалын индикатор P-г зааж байгаа эсэхийг нягтална.

| Арааны байрлал | Зориулалт ба функц                        |
|----------------|-------------------------------------------|
| P              | Зогсоолд байрлуулах/ хайбрид систем асаах |
| R              | Ухрах                                     |
| N              | Сул араа (Хүч дамжихгүй араа)             |
| D              | Хэвийн жолоодлого* <sup>1</sup>           |
| S              | S жолоодлогын горим* <sup>2</sup>         |

\*1: Шатахуун зарцуулалтыг сайжруулах, дуу чимээг бууруулах үүднээс хэвийн жолоодлогын үед D арааны байрлал сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүрэг ашиглан жолоодлогод солигдох дээд арааг сонгох боломжтой.

\*2: S горимоор жолоодох үед солигдох дээд арааг сонгох боломжтой.


## Жолоодлогын горим сонгох

### ■ Жолоодлогын горим

→P. 55

## D араанд солигдох дээд арааг сонгох

Нэмэлт хөшүүргийн “-” товч дарах үед жолоодлогод нийцсэн хөдөлгүүрийн тоормос гаргах сонгох боломжтой дээд араанд шилжинэ. “+” товч дарж илүү хөнгөн араа хүртэл араа солих хязгаарыг нэмэгдүүлнэ.



**1** Хөнгөн араанд шилжүүлэх

**2** Хүнд араанд шилжүүлэх

Хянах самбар дээр тухайн сонгосон D1-с D5 хүртэлх солигдох боломжтой арааны дээд хязгаарыг харуулна.

“-” товч дарах үед автоматаар D4 араанд шилжинэ.


Хэвийн жолоодлогын D байрлалд буцаах үед “+” товчийг тодорхой хугацаанд дарах эсвэл D5 араанд “+” товчийг дарна.

### ■ Араа шилжих хязгаар ба тэдгээрийн функц

- 5 түвшний хөдөлгүүрийн хүчнээс сонгох боломжтой.
- Хөнгөн араанаас хүнд араа нь илүү хүчтэй хөдөлгүүрийн тоормосны хүч үүсгэх ба улмаар хөдөлгүүрийн эргэлт нэмэгдэнэ.

## S горимд араа сонгох

Арааны хөшүүргийг S байрлалд сэлгэж S горимыг сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг хөдөлгөн жолоодох арааг сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн “-” болон “+” талыг дарж шилжих боломжтой арааны хязгаарыг тохируулна.



**1** Хөнгөн араанд шилжүүлэх

**2** Хүнд араанд шилжүүлэх


S1-с S6 хүртэлх сонгосон араанд түгжигдэж тухайн араа дэлгэц дээр гарна.

S горимд шилжүүлэх үед автоматаар S4 араанд шилжинэ.

■ Араа шилжих хязгаар ба эдгээрийн функц

- 6 түвшний хөдөлгүүрийн хүчнээс сонгох боломжтой.
- Хөнгөн араанаас хүнд араа нь илүү хүчтэй хөдөлгүүрийн тоормосны хүч үүсгэх ба улмаар хөдөлгүүрийн эргэлт нэмэгдэнэ.

## Эргэх дохионы хөшүүрэг



- 1 Баруун гар тийш эргэх
- 2 Баруун гар тийш эгнээ солих (хөшүүргийг хагас түлхэх)  
Баруун дохионы гэрэл 3 удаа анивчина.
- 3 Зүүн гар тийш эгнээ солих (хөшүүргийг хагас түлхэх)  
Зүүн дохионы гэрэл 3 удаа анивчина.
- 4 Зүүн гар тийш эргэх

## Зогсоолын тоормос


Зогсоолын тоормосыг автоматаар мөн гар аргаар залгах, салгах боломжтой.

Автомат горим сонгогдсон үед арааны хөшүүргийн ажиллагаанаас хамаарч зогсоолын тоормос автоматаар залгагдах буюу салгагдана.

Автомат горимтой үед ч зогсоолын тоормосыг гараар залгах, салгах боломжтой.

### Гар аргаар ажиллуулах горим ашиглах

Зогсоолын тоормосыг гар аргаар залгах, салгах боломжтой.



**A** Зогсоолын тоормосны индикатор

**1** Товч татаж тоормос залгана.

Зогсоолын тоормосны индикатор асна.

Жолоодлогын үед онцгой байдал үүсч зогсоолын тоормос татах шаардлагатай тохиолдолд зогсоолын тоормосны товчийг татаад барина.

**2** Товчийг доош дарж тоормосыг салгана.

- Тоормосны дөрөө гишгэнгээ зогсоолын тоормосны товчийг ажиллуулна.
- Зогсоолын тоормос автоматаар салгах функц ашиглан зогсоолын тоормосыг хаазны дөрөө гишгэн салгах боломжтой. Тус функцийг ашиглах үед хаазны дөрөөг бага зэрэг гишгэнэ.

Зогсоолын тоормосны индикатор унтарсан эсэхийг нягтална.

Зогсоолын тоормосны индикатор анивчиж байгаа үед товчийг дахин ажиллуулна.

## **Автомат горим асаах**

Автомашин зогссон үед дуут дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарах хүртэл зогсоолын тоормосны товчийг татна.

Автомат горим сонгогдсон үед зогсоолын тоормос дараах байдлаар ажиллана.

- Арааны хөшүүргийг Р-с шилжүүлэх үед зогсоолын тоормос салгагдах ба зогсоолын тоормосны индикатор унтарна.
- Арааны хөшүүргийг Р-д шилжүүлэх үед зогсоолын тоормос залгагдах ба зогсоолын тоормосны индикатор асна.

Автомашин зогссон бөгөөд тоормосны дөрөө гишгэсэн үед арааны хөшүүрэг болон Р арааны товч ажиллуулна.

Арааны хөшүүргийг хурдан хөдөлгөсөн үед автомат функц ажиллахгүй байж болно. Энэ нөхцөлд зогсоолын тоормосыг гар аргаар залгана.

## **Автомат горимыг унтраах**

Автомашин зогссон ба тоормосны дөрөө гишгэсэн үед дуут дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарах хүртэл зогсоолын тоормосны товчийг удаан дарна.


## Тоормос баригч

### ► RX500h

Арааны хөшүүрэг D, M эсвэл N арааны байрлалд тоормосны дөрөөгөөр автомашиныг зогсоосон үед тоормос баригч систем тоормосыг үргэлжлүүлэн барьдаг. Систем нь арааны хөшүүрэг D, M араанд хаазны дөрөө гишгэх үед хөдөлгөөнийг зөөлөн эхлэх боломж бүрдүүлж тоормос сулладаг.

### ► RX350h

Арааны хөшүүрэг D, S эсвэл N арааны байрлалд тоормосны дөрөөгөөр автомашиныг зогсоосон үед тоормос баригч систем тоормосыг үргэлжлүүлэн барьдаг. Систем нь арааны хөшүүрэг D, S араанд хаазны дөрөө гишгэх үед хөдөлгөөнийг зөөлөн эхлэх боломжийг бүрдүүлж тоормосыг сулладаг.



### Тоормос баригч идэвхжүүлэх

Тоормос баригч ажиллахад бэлэн байгааг илтгэх индикатор (ногоон) **A** асна. Систем тоормос барьж байгаа үед тоормос баригчийн индикатор (шар) **B** асна.

## Мэдээллийн дэлгэц

### Дэлгэцээр гарах мэдээллийн агуулга

#### ■ Дэлгэц

Жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээлэл гарна. Тухайн байдлаас хамаарч анхааруулга, зөвлөгөөний нэмэлт мэдээлэл гарч болно.

#### ■ Дэлгэц дээр гарах зүйлс

► HUD дэлгэцгүй автомашин

Мэдээллийн дэлгэцийн меню тэмдэгээр дараах чиглэлийн мэдээлэл гарна.



Жолоодлогын мэдээллийн дэлгэц



Навигацийн системтэй холбоотой дэлгэц (тоноглогдсон автомашинд)



Аудио системтэй холбоотой дэлгэц



Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц



Анхааруулах мэдээлэл

► HUD дэлгэцтэй автомашин

Дараах зүйлс дэлгэц дээр гарах боломжтой.

- Жолоодлогын мэдээлэл 1
- Жолоодлогын мэдээлэл 2
- Энергийн монитор/EV жолоодлогын харьцаа
- Аудио системтэй холбоотой дэлгэц
- Навигацийн системтэй холбоотой дэлгэц (тоноглогдсон автомашинд)\*
- Турбоны даралт хэмжигч/хөдөлгүүрийн тосны хэм хэмжигч/хөдөлгүүрийн тосны даралт хэмжигч
- G-хүч
- RX500h: Арааны байрлал
- Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц\*
- Хоосон (Дэлгэц дээр мэдээлэл гарахгүй)


\*: Дэлгэцийн “Мах” горимд HUD дэлгэц дээр гарна.

Автомашины аль нэг системд асуудал үүссэн үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна.

# Дэлгэцээр гарах мэдээллийн агуулга


## Бүрдэл хэсгүүд/ажиллагаа

### ► HUD дэлгэцгүй автомашин



- A** < / > : Меню тэмдэг сонгох  
^ / v : Дэлгэцээр гарах мэдээллийн агуулга солих, дэлгэц дээш доош гүйлгэх, курсор дээш доош шилжүүлэх
- B** Өмнөх дэлгэц рүү буцах
- C** Дуудлага хийх/хүлээн авах  
Гарын оролцоогүй утасны системтэй холбогдсон дуудлагын мэдээлэл дэлгэц дээр гарна. Гарын оролцоогүй утасны системийн тухай дэлгэрэнгүйг "Мултимедиа системийн хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.
- D** Орох/Сонгох

## ► HUD дэлгэцтэй автомашин



**A** Голын дэлгэц

**B** Жолооны хүрдний товч

Тухайн нөхцөл болон тохиргооноос хамаарч товч тус бүрийн функц өөрчлөгдөнө.

Товч дарах үед HUD дэлгэц дээр товч тус бүрийн функц гарна. HUD дэлгэц унтраастай эсвэл HUD дэлгэц дээр контент гаргах боломжгүй үед функцууд мэдээллийн дэлгэц дээр гарна.

Мөн товч тус бүрийн түлхүү ашиглах функцийг голын дэлгэц дээр тохируулах боломжтой.

**C** Товчны ажиллагаа солих товч

Тус товчийг дарах бүрт функц өөрчлөгдөнө.

**D** Товчны тэмдгийн дэлгэц

Товч тус бүрийн тэмдэг дэлгэц дээр гарна. Дарсан товч тодорно. (**F**)

**E** Товчны функцийг тайлбарлах дэлгэц

Дарсан товчны функцийг тайлбар гарна.

HUD дэлгэц нь ялангуяа туйлширсан туяаны болон бусад төрлийн нарны шилтэй үед бүдэг харагдаж болно. Энэ үед HUD дэлгэцийн гэрлийн түвшинг тохируулах эсвэл нарны шилээ тайлна.

## Энергийн монитор/EV жолоодлогын харьцаа (тоноглогдсон автомашинд)

Энергийн монитор болон EV жолоодлогын харьцааг мэдээллийн дэлгэц дээр гаргах боломжтой.

Энергийн монитторыг голын дэлгэц дээр гаргах боломжтой

### ■ Энергийн монитторыг голын дэлгэц дээр гаргах

1 Үндсэн цэснээс -г сонгоно.

2 “Energy flow”-г сонгоно.

### ■ Энергийн монитор

Энергийн монитороор автомашины жолоодлого, хайбрид системийн болон цэнэг дахин сэргээх ажиллагаа зэргийг нягтлах боломжтой.


Энергийн урсгалыг сумаар илэрхийлнэ. Урсгал байхгүй үед сум гарахгүй.

Сумны өнгө дараах байдлаар өөрчлөгдөнө

- Цэнхэр: Хайбрид батарей (хөтлөх батарей) цэнэг сэргээх эсвэл цэнэглэх
- Шаргал: Хайбрид батарей (хөтлөх батарей) ашиглагдаж байгаа
- Улаан: Бензин хөдөлгүүр ашиглагдаж байгаа

Зурагт бүх сумыг жишээ болгон харуулав. Ашиглалтын нөхцөлөөс хамаарч бодит дэлгэц өөр байна.

► Мэдээллийн дэлгэц




A Бензин хөдөлгүүр

B Дугуй

C Хайбрид батарей (хөтлөх батарей)

Тус зураг нь зөвхөн тайлбарлах зорилготой ба автомашины техник үзүүлэлтээс хамаарч өөр байж болно.

► Голын дэлгэц



A Бензин хөдөлгүүр

B Урд цахилгаан мотор (хөтлөх)

C Хайбрид батарей (хөтлөх батарей)

D Хойд цахилгаан мотор (хөтлөх)  
(тоноглогдсон автомашинд)

E Хойд дугуй

F Урд дугуй

## ■ Ассанаас хойших EV жолоодлогын харьцаа (тоноглогдсон автомашинд)

Ассанаас хойших EV жолоодлогын харьцааг харуулна.

Хайбрид систем унтрах бүрт тус заалт тэглэгдэнэ.


### Одоогийн шатахуун зарцуулалт/түүхийн дэлгэц

Голын дэлгэц дээр шатахуун зарцуулалтын мэдээлэл гаргах боломжтой.

## ■ Голын дэлгэц дээр одоогийн шатахуун зарцуулалт/түүхийн дэлгэц гаргах

- 1 Үндсэн цэснээс -г сонгоно.
- 2 “Trip information”-г сонгоно.
- 3 “Current” эсвэл “History”-г сонгоно.


## ■ Одоогийн шатахуун зарцуулалтын дэлгэц



- A Түүхийн өгөгдлийг тэглэх
- B 15 минутын шатахуун зарцуулалт
- C Одоогийн шатахуун зарцуулалт
- D Хайбрид систем ассанаас хойших автомашины дундаж хурд
- E Туулах боломжтой зай
- F Систем ассанаас хойших хугацаа

Тухайн заалтыг мэдээллийн журмаар ашиглана. Зураг нь жишээ бөгөөд бодит байдлаас өөр байж болно.

## ■ Шатахуун зарцуулалтын түүхийн дэлгэц




- A Сүүлийн шатахуун зарцуулалт
- B Хамгийн сайн шатахуун зарцуулалт
- C Шатахууны түүхийн өмнөх бүртгэл
- D Түүхийн өгөгдөл тэглэх
- E Сүүлийн шатахуун зарцуулалтыг шинэчлэх

Тухайн заалтыг мэдээллийн журмаар ашиглана. Зураг нь жишээ бөгөөд бодит байдлаас өөр байж болно.


## Их гэрлийн асаагуур

### ► А төрөл




- 1  Урд оврын, арын, хойд хажуугийн оврын, улсын дугаарын болон хянах самбарын гэрэл асна.
- 2  Их гэрэл болон дээр дурдсан бүх гэрэл асна.
- 3  AUTO Их гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл болон дээр дурдсан бүх гэрэл автоматаар асах буюу унтарна.  
(Асаах товчны ON горимд.)

### ► В төрөл



- 1  Урд оврын, арын, хойд хажуугийн оврын, улсын дугаарын болон хянах самбарын гэрэл асна.
- 2  Их гэрэл болон дээр дурдсан бүх гэрэл асна.
- 3  AUTO Их гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл болон дээр дурдсан бүх гэрэл автоматаар асах буюу унтарна.  
(Асаах товчны ON горимд.)
- 4  О Өдрийн хөдөлгөөний гэрэл асна.

## Холын гэрэлд шилжүүлэх



**1** Их гэрэл асаалттай үед хөшүүргийг урагш түлхэж холын гэрэлд шилжүүлнэ.

Хөшүүргийг голын байрлал руу буцааж холын гэрлийг унтраана.


**2** Хөшүүргийг нааш татаж холын гэрлийг нэг удаа асаана.

Их гэрлийг асааж унтраах байдлаар гэрлээрээ дохих боломжтой.


## AHS холын гэрэл (тоноглогдсон автомашинд)

AHS холын гэрэл нь салхины шилний дээд хэсгийн дотор талд байрлах урд камераар замын гэрэлтүүлэг, орчны болон зөрж өнгөрч буй автомашин зэргийн гэрлийг мэдэрдэг ба шаардлагатай үед их гэрлийн тусгалыг автоматаар хуваарилдаг.

### AHS систем идэвхжүүлэх



- 1 AHS системийн товчийг дарна.




- 2 Их гэрлийн асаагуурыг AUTO эсвэл  байрлалд шилжүүлнэ.

Их гэрлийн асаагуур ойрын гэрлийн байрлалд байгаа үед AHS систем идэвхжиж AHS индикатор асна.

## Холын гэрлийг гар аргаар асаах/унтраах

### ■ Холын гэрэлд шилжүүлэх




Хөшүүргийг урагш түлхэнэ.

AHS системийн индикатор унтарч холын гэрлийн индикатор асна.

AHS системийг дахин идэвхжүүлэх үед хөшүүргийг анхны байрлалд буцаана.

### ■ Ойрын гэрэлд шилжүүлэх




AHS системийн товч дарна.

AHS системийн индикатор унтарна.

AHS системийг дахин идэвхжүүлэх үед товчийг дахин дарна.

### ■ Ойрын гэрэлд түр шилжүүлэх




Хөшүүргийг нааш татаад анхны байрлалд буцаана.

Хөшүүргийг нааш татах хугацаанд холын гэрэл асах ба хөшүүргийг анхны байрлалд буцаасны дараа тодорхой хугацаанд ойрын гэрэл асаад AHS холын гэрлийн горимд шилжинэ.


## АНВ холын гэрэл (тоноглогдсон автомашинд)

Автомат холын гэрэл нь салхины шилний дээд талд байрлах урд камер ашиглан урд талын автомашин, замын гэрэлтүүлэг зэргийн гэрлийн түвшинг мэдрэх ба их гэрлийг холын болон ойрын гэрэлд автоматаар шилжүүлдэг.

### Автомат холын гэрлийн систем ашиглах



- 1 Автомат холын гэрлийн товчийг дарна.




- 2 Их гэрлийн асаагуурыг AUTO эсвэл  байрлалд шилжүүлнэ.

Их гэрлийн хөшүүрэг ойрын гэрлийн байрлалд байгаа үед АНВ систем идэвхжиж АНВ индикатор асна.

## Холын гэрлийг гараар асаах, унтраах

### ■ Холын гэрэлд шилжүүлэх




Хөшүүргийг урагш түлхэнэ.

АНВ индикатор унтарч холын гэрлийн индикатор асна.

Хөшүүргийг анхны байрлалд татаж автомат холын гэрлийн системийг дахин идэвхжүүлнэ.

### ■ Ойрын гэрэлд шилжүүлэх




Автомат холын гэрлийн товч дарна.

АНВ индикатор унтарна.

Товчийг дахин дарж автомат холын гэрлийг идэвхжүүлнэ.

### ■ Ойрын гэрэлд түр шилжүүлэх




Хөшүүргийг арагш татаад анхны байрлалд буцаана.

Хөшүүргийг татах хугацаанд холын гэрэл асах ба анхны байрлалд буцаах үед ойрын гэрэл тодорхой хугацаанд асна. Үргэлжлээд автомат холын гэрлийн систем ажиллана.

## Манангийн гэрлийн товч

Бороо, манан зэрэг жолоодлогын хүнд нөхцөлд урд манангийн гэрэл/хойд манангийн гэрлийг асааж урд талын үзэгдэх орчинг сайжруулахаас гадна манангийн гэрлээ асааж бусад жолооч нарт өөрийн автомашинаа мэдэгдэх боломжтой.


### ► Урд манангийн гэрлийн товч



1 ○ Урд манангийн гэрэл унтраах

2  Урд манангийн гэрэл асаах

► Урд ба хойд манангийн гэрлийн товч






- 1 ○ Урд ба хойд манангийн гэрэл унтраах
- 2 𐄢 Урд манангийн гэрэл асаах
- 3 𐄣 Урд ба хойд манангийн гэрэл зэрэг асаах

Товчны цагирагийг 𐄢-д буцаана.

Товчны цагирагийг дахин ажиллуулах үед зөвхөн хойд манангийн гэрэл унтарна.

## Салхины шил арчигч, угаагч


AUTO сонгогдсон ба мэдрэгч бороо орж байгааг мэдэрсэн үед шил арчигч автоматаар ажиллана. Систем борооны хэмжээ болон автомашины хурдад тааруулан шил арчигчийн ажиллах хурдыг автоматаар тохируулна.



- 1 ○ Off
- 2 AUTO Бороо мэдрэгчийн ажиллагаа
- 3 ▼ Удаан
- 4 ▼ Хурдан
- 5 △ Нэг удаа арчих

AUTO-г сонгосон үед хөшүүргийн цагираг эргүүлэн мэдрэгчийн мэдрэх түвшинг тохируулна.

- 6 Мэдрэх түвшинг нэмэгдүүлэх
- 7 Мэдрэх түвшинг багасгах



## 8 Шил арчигч/угаагч давхар ажиллах




Хөшүүргийг татах үед шил арчигч автоматаар ажиллана.

(Шил арчигч хэд хэдэн удаа ажиллаад тодорхой хугацааны дараа шилэн дээр үлдэгдэл ус урсахаас сэргийлж дахин нэг ажиллана. Нөгөөтээгүүр автомашин явж байгаа үед үлдэгдэл ус урсахаас сэргийлэх зорилгоор дахин ажиллахгүй.)

Их гэрэл угаагчтай автомашин:

Асаах товчны ON горимд их гэрэл асаалттай үед хөшүүргийг татахад их гэрэл угаагч нэг удаа ажиллана. Үргэлжлүүлэн хөшүүргийг таван удаа татах тутамд их гэрэл угаагч нэг удаа ажиллана.

## Хойд шил арчигч, угаагч



- 1 ○ Off
- 2 --- Тасалдсан горим
- 3 — Хэвийн горим

### 4 Шил арчигч/угаагч давхар ажиллах

Хөшүүргийг түлхэх үед шил арчигч болон угаагч ажиллана.

Шингэн цацагдсаны дараа шил арчигч автоматаар 2 удаа ажиллана.


Камер угаагчтай автомашин: Угаагч автоматаар ажиллаж арын камер цэвэрлэнэ.\*

\*: Дэлгэрэнгүйг “Мултимедиа гарын авлага”-с харна уу.

## Жолоодлогын горим сонгох товч

Жолоодлогын нөхцөлд тохируулан жолоодлогын горим сонгох боломжтой.

- 1 Голын дэлгэцнээс -г сонгоно.
- 2 “Drive mode”-г сонгоно.
- 3 Жолоодлогын горимыг сонгоно.



### 1 Хэвийн горим

Шатахуун бага зарцуулалт, дуу чимээ бага, динамик гүйцэтгэлийг тэнцвэртэйгээр бүрдүүлэх горим. Хотын жолоодлогод тохиромжтой.

### 2 Эко жолоодлогын горим

Хөдөлгүүрийн хаазыг удирдах, агааржуулалтын системийн ажиллагааг удирдах (халуун/хүйтэн) замаар шатахуун зарцуулалтыг сайжруулах мөн байгаль орчинд ээлтэйгээр хөдөлгөөн эхлэхэд жолоочид тусална.

Горим идэвхжих үед эко горимын индикатор асна.

### 3 Sport горим

AVS системгүй автомашин: Хайбрид систем удирдах замаар хүчтэй хурд авалтыг бий болгоно. Эргэлт ихтэй замаар зорчих үед эрч хүчтэй жолоодлого бүрдүүлэх үүднээс тус горим жолооны хүрднээс ирэх мэдрэмжийг өөрчилдөг.

AVS системтэй автомашин: Хайбрид систем, амортизатор, жолооны механизмыг цогцоор удирдах замаар жолоодлого болон тогтвортой байдлыг бүрдүүлж спорт жолоодлого хийхэд тохиромжтой болгодог.

Sport горим сонгогдох үед “Sport” индикатор асна.

#### 4 Custom горим

Хүч дамжуулах анги, жолооны механизм, явах анги\* болон агааржуулалтын системийн ажиллагааг таны хүссэн тохиргоонд тохируулна.

Тус горимыг сонгох үед Custom горимын индикатор асна.

\*: AVS (Adaptive Variable Suspension) системтэй автомашин

# Ухаалаг утас ба бусад төхөөрөмж холбох

## Мултимедиа систем ашиглан Bluetooth® төхөөрөмж бүртгэх

Гарын оролцоогүй дуудлага хийх эсвэл Bluetooth® хөгжим ашиглахын өмнө гар утас эсвэл зөөврийн төхөөрөмжийг бүртгүүлнэ. Бүртгэл дууссан үед мултимедиа систем асах бүрт Bluetooth® автоматаар холбогдоно.

Apple CarPlay/Android Auto төхөөрөмж USB-р холбогдсон үед төхөөрөмж автоматаар Bluetooth® төхөөрөмж гэж бүртгэгдэнэ.

Bluetooth® төхөөрөмж холбогдоогүй үед жолооны хүрдний  товчийг удаан дарж бүртгэлийн дэлгэцийг гаргана.


1 Үндсэн цэсний -г дарна.

2 Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.

Төхөөрөмж бүртгэгдээгүй үед 4-р үйлдэл рүү шилжинэ үү.

3 [Add another device]-г дарна.

Төхөөрөмж мултимедиа системд холбогдох үед төхөөрөмжийг салгах үйлдлийг баталгаажуулах дэлгэц гарч ирж болно. Төхөөрөмжийг бүртгэх үед төхөөрөмжийг салгана.



4 [If not found]-г дарна.

5 Үндсэн хэсгээс төхөөрөмжийг сонгож бүртгэнэ.

- Төхөөрөмжийн нэрийн оронд Bluetooth® хаяг дэлгэцээр гарч болно.
- Үндсэн хэсэг дээр төхөөрөмж бүртгэх бүртгэл гарахгүй үед Bluetooth® төхөөрөмжөөс бүртгэх оролдлого хийнэ.
- Bluetooth® төхөөрөмжийн зарим загварууд Bluetooth® төхөөрөмжийн дэлгэц дээрээ сонгоогүй үед төхөөрөмжийн жагсаалт дотор гарч ирэхгүй байж болно. Дэлгэрэнгүйг Bluetooth® төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.

6 Дэлгэц дээрх PIN код Bluetooth® төхөөрөмжийн PIN кодтой таарч байгаа эсэхийг нягтлаад [OK]-г дарна.

- Бүртгэлийг дуусгахын тулд зарим Bluetooth® төхөөрөмжийг ажиллуулах шаардлагатай байдаг.
- Зарим тохиолдолд бүртгэл хийх зааварчилгаа дэлгэцээр гарч болно. Зааварчилгааны дагуу бүртгэл хийнэ.
- Apple CarPlay-н тохиргоо дэлгэцээр гарч болно. Зөвшөөрсөн тохиргоо хийсэн үед Apple CarPlay-н дэлгэц дэлгэцээр гарна.
- Холболт амжилттай хийгдсэнийг илтгэх мэдээлэл дэлгэцээр гарах ба бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж дэд цэс дотор гарна.
- Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх мэдээлэл гарсан үед дэлгэцийн зааварчилгааны дагуу үйлдэл хийнэ.

## ■ Бүртгэлийг Bluetooth® төхөөрөмжөөс хийх

Мултимедиа систем дээр хайлт хийсэн ч Bluetooth® төхөөрөмж илрэхгүй үед дараах дарааллын дагуу Bluetooth® төхөөрөмжөөс мултимедиа системийн бүртгэл хийнэ.


1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.

2 Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.

Төхөөрөмж бүртгэгдээгүй үед 4-р үйлдэлд шилжинэ үү.

3 [Add another device]-г дарна.

Төхөөрөмж мултимедиа системд холбогдох үед төхөөрөмжийг салгах үйлдлийг баталгаажуулах дэлгэц гарч ирж болно. Төхөөрөмжийг бүртгэх үед төхөөрөмжийг салгана.



4 Bluetooth® төхөөрөмж дээр ашиглах мултимедиа системийг бүртгэнэ.


- Bluetooth® төхөөрөмжийн үйлдлийн дарааллын дагуу үйлдэл хийнэ.
- Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл хийх үйлдлийг эхлэхээс өмнө тус Bluetooth® холболтын дэлгэцийг гаргана.

5 Дэлгэц дээрх PIN код Bluetooth® төхөөрөмжийн PIN кодтой таарч байгааг нягтлаад [OK]-г дарна.

- Бүртгэлийг дуусгахын тулд зарим Bluetooth® төхөөрөмжийг ажиллуулах шаардлагатай байдаг.
- Зарим тохиолдолд бүртгэл хийх зааварчилгаа дэлгэцээр гарч болно. Зааварчилгааны дагуу бүртгэл хийнэ.
- Apple CarPlay-н тохиргоо дэлгэцээр гарч болно. Зөвшөөрсөн тохиргоо хийсэн үед Apple CarPlay-н дэлгэц дэлгэцээр гарна.
- Холболт амжилттай хийгдсэнийг илтгэх мэдээлэл дэлгэцээр гарах ба бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмж дэд цэс дотор гарна.
- Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх мэдээлэл гарсан үед дэлгэцийн зааварчилгааны дагуу үйлдэл хийнэ.

## ■ Жолооны хүрдний товч ашиглан удирдах (А төрөл)

Жолооны хүрдний товч ашиглан дуудлага авах, дуудлага хийх зэрэг зарим гарын оролцоогүй дуудлагын функц ашиглах боломжтой. Мультимедиа системийн ажиллагааны статусаас хамаарч жолооны хүрдний товчны функц өөрчлөгдөнө.



● Товч дарж үйлдэл хийнэ.

[+] товч

Хонхны аяны дууны түвшин эсвэл хүлээн авагчийн дууны түвшинг нэмнэ.

Удаан дарж үргэлжлүүлэн тохируулна.

[-] товч

Хонхны аяны дууны түвшин эсвэл хүлээн авагчийн дууны түвшинг хасна.

Удаан дарж үргэлжлүүлэн тохируулна.

[] товч

Дуу хоолойн командаар дуудлага хийх боломжтой.

Дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарж дуу хоолойн командыг дуусгана.

[] товч


- Мультимедиа систем дуудлагын дэлгэцнээс бусад дэлгэц гаргаж байгаа үед дуудлагын түүхийг харуулна.
- Мультимедиа систем дуудлагын дэлгэц дээр []-г гаргаж байгаа үед дуудлага хийнэ.
- Мультимедиа систем дуудлагын дэлгэц дээр []-г гаргаагүй үед дуудлагын түүх гаргана.

- Дуудлага хийх, утсаар ярих үед дуудлагыг дуусгана.
- Дуудлага ирэх, дуудлага хүлээгдэх үед дуудлагыг авна.

## ■ Жолооны хүрдний товч ашиглан удирдах (B төрөл)

Жолооны хүрдний товч ашиглан дуудлага авах, дуудлага хийх зэрэг зарим гарын оролцоогүй дуудлагын функц ашиглах боломжтой. Мультимедиа системийн ажиллагааны статусаас хамаарч жолооны хүрдний товчны функц өөрчлөгдөнө.

Жолооны хүрдний товч нь электростатик товч юм. Товчийг товших үед товч ажиллана. Мультимедиа системийн ажиллагааны статусаас хамаарч дэлгэцээр гарах товчны байрлал болон функц өөрчлөгдөнө.



- Товч дарж үйлдэл хийнэ.

[+] товч

Хонхны аяны дууны түвшин эсвэл хүлээн авагчийн дууны түвшинг нэмнэ.

Удаан дарж үргэлжлүүлэн тохируулна.

[-] товч

Хонхны аяны дууны түвшин эсвэл хүлээн авагчийн дууны түвшинг хасна.

Удаан дарж үргэлжлүүлэн тохируулна.

[] товч

Дуу хоолойн командаар дуудлага хийх боломжтой.

Дуудлага хийх, яриаг дуусгах товч удаан дарж дуут командыг дуусгана.

[] товч

- Мультимедиа систем дуудлагын дэлгэцнээс бусад дэлгэц гаргаж байгаа үед дуудлагын түүхийг харуулна.
- Мультимедиа систем дуудлагын дэлгэц дээр []-г гаргаж байгаа үед дуудлага хийнэ.
- Мультимедиа систем дуудлагын дэлгэц дээр []-г гаргаагүй үед дуудлагын түүх гаргана.
- Дуудлага солих/яриж буй дуудлагыг хүлээлгэнд оруулна.
- Дуудлага ирэх, дуудлага хүлээгдэх үед дуудлагыг авна.


[] товч

- Дуудлага хийх, утсаар ярих үед дуудлагыг дуусгана.
- Дуудлага ирэх, дуудлага хүлээгдэх үед дуудлагыг цуцлана.

## Дуудлагын түүхээс дуудлага хийх

Ирсэн, залгасан дуудлагын түүхэнд бүртгэгдсэн утасны дугаар ашиглан дуудлага хийх боломжтой.

- 1 Үндсэн цэсний [📞]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Recents]-г дарна.




- 3 Холбоо барих хаягийг сонгоно.  
Холбоо барих хаягт бүртгэгдээгүй утасны дугаарын зөвхөн дугаар дэлгэцээр гарна.
- 4 Дуудлага хийх утасны дугаарыг сонгоно.

## Тогтмол ашигладаг дугаарын жагсаалтаас дуудлага хийх

Тогтмол ашигладаг дугаарын жагсаалтад дугаар бүртгэж дуудлага хийх боломжтой.

- 1 Үндсэн цэсний [📞]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Favorites]-г дарна.




- 3 Тогтмол ашигладаг дугаарын жагсаалтаас дуудлага хийх хүний дугаарыг сонгоно.
- 4 Дуудлага хийх утасны дугаарыг сонгоно.

## Холбоо барих хаягнаас дуудлага хийх

Мултимедиа системд бүртгэсэн холбоо барих хаягнаас дуудлага хийх боломжтой.


- 1 Үндсэн цэсний [📞]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Contacts]-г дарна.
- 3 Холбоо барих хаягийг сонгоно.



- 4 Дуудлага хийх утасны дугаарыг сонгоно.

## Дуудлага хүлээн авах

Дуудлага хүлээн авах үед дуудлагын хонх дуугарах ба ирж буй дуудлагын дэлгэц эсвэл анхааруулга дэлгэцээр гарна. Дуу хоолойн командын [Voice support] идэвхтэй үед дуу хоолойн команд ажиллаж эхэлнэ.



- Дараах үйлдлээр хүлээн авна.
  - [📞]-г дарна.
  - Жолооны хүрдний [📞] товч дарна.
  - Дуу хоолойн командын системд дуу хоолойн команд өгнө.

## Мессежний функцээс дуудлага хийх (БНСУ, Тайваниас бусад)

Мессежний функцээс гарын оролцоогүй дуудлага хийх боломжтой.

Тус функц зарим улс орон, бүс нутагт ашиглагдах боломжгүй.


● Цэнхэр дугаар дээр дарж дуудлага хийнэ.

Дараалсан тоонуудыг систем утасны дугаар гэж таньж болно. Мөн гадаад утасны дугаар зэрэг зарим утасны дугаар танигдахгүй байж болно.

### ■ И-мэйл, SMS эсвэл MMS мессежний дэлгэцээс дуудлага хийх

И-мэйл, SMS эсвэл MMS мессеж илгээгч рүү дуудлага хийх боломжтой. И-мэйлний хувьд утасны дугаар тус холбоо барих хаяг дээр бүртгэгдсэн байх ёстой.

- 1 Үндсэн цэсний [  ]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Messages]-г дарна.
- 3 Аккаунт сонгоно.
- 4 Мессеж илгээгчийг сонгоно.



- 5 Жолооны хүрдний [  ] эсвэл [  ] товч дарна.

Холбоо барих бүртгэлээс хамаарч утасны дугаар сонгох шаардлагатай.

## Агааржуулалтын автомат горим

Агааржуулалтын автомат горимтой суудлууд нь агааржуулалтын системийн хэмийн тохиргоо, гадна болон салоны агаарын хэмтэй уялдан автоматаар ажиллана. Тус функц нь систем тус бүрийг тохируулах шаардлагагүйгээр тав тухыг хангана.

## Агааржуулалтын автомат горим асаах

Агааржуулалтын автомат горим нь агааржуулалтын системийн “AUTO” горимтой зэрэг ажилладаг.

- 1 Сонголтын дэлгэцийн товч дарна.
- 2 “Climate concierge” товч дарна.
- 3 “AUTO” товчийг асаана.


## Урд автомат агааржуулалтын систем

“AUTO” товч асаалттай үед температурын тохиргооноос хамаарч агааржуулагчийн байрлал, сэнсний хурд автоматаар тохируулагдана.

Баруун жолооны хүрдтэй автомашинд товчны байрлал болон хэлбэр өөр байна. Мөн системийн төрлөөс хамаарч дэлгэц болон товчны байрлал өөр байна.

### Сонголтын дэлгэцийн товч

► 14 инчийн голын дэлгэцтэй загвар



**A** Зүүн талын температур удирдлагын товч

**B** Агаарын урсгалын горим солих товч

**C** Сонголтын дэлгэцийн товч

**D** Товчлол дэлгэцийн товч

Олон төрлийн функцийн товчлолын тэмдэг гаргах үед сонгоно.

**E** Урд/хойд удирдлагын дэлгэцийн товч

**F** “SYNC” товч

**G** Баруун талын температур удирдлагын товч

**H** “A/C” товч


**I** Гадна агаар/дотор агаарын горимд солих товч

**J** Сэнсний хурд тохируулах товч

**K** “OFF” товч

**L** “AUTO” товч

► 9.8 инчийн голын дэлгэцтэй загвар



- A** Зүүн талын температур удирдлагын товч
- B** Агаарын урсгалын горим солих товч
- C** Сонголтын дэлгэцийн товч
- D** Товчлол дэлгэцийн товч  
Олон төрлийн функцийн товчлолын тэмдэг гаргах үед сонгоно.
- E** Баруун талын температур удирдлагын товч
- F** “SYNC” товч
- G** “A/C” товч
- H** Гадна агаар/дотор агаарын горимд солих товч
- I** Сэнсний хурд тохируулах товч
- J** “OFF” товч
- K** “AUTO” товч


## Арын агааржуулалтын систем

Арын агааржуулалтын системийг голын дэлгэцийн “Rear” товч болон арын агааржуулалтын системийн удирдлагын самбараар удирдах боломжтой.

### Арын агааржуулалтын системийн удирдлага

#### ■ Голын дэлгэц

► 14 инчийн голын дэлгэцтэй загвар




**A** Арын суудлын хэм тохируулах товч

Хэм тохируулах хүрдийг цагийн зүүний дагуу эргүүлж хэм нэмэх ба эсрэг эргүүлж хасна.

**B** Арын агааржуулалтын системийн удирдлагын дэлгэц хаана.

► 9.8 инчийн голын дэлгэцтэй загвар



**A** Арын суудлын хэм тохируулах товч

Хэм тохируулах хүрдийг цагийн зүүний дагуу эргүүлж хэм нэмэх ба эсрэг эргүүлж хасна.


**B** Арын агааржуулалтын системийн удирдлагын дэлгэц хаана.

## Хажуу хаалга

Түлхүүрийн алсын удирдлага, хаалга түгжих товч, Entry функц ашиглан автомашиныг түгжих, түгжээ тайлах боломжтой.

### Дотор талаас хаалга түгжих, тайлах

#### ■ Хаалга түгжих товч (түгжих/тайлах)



**1** Жолоочийн хаалга: Бүх хаалга түгжих

Жолоочийн хаалганаас бусад:  
Тухайн хаалга түгжих


**A** индикатор асна.

**2** Жолоочийн хаалга: Бүх хаалганы түгжээ тайлах

Жолоочийн хаалганаас бусад:  
Тухайн хаалганы түгжээ тайлах

**A** индикатор унтарна.


### Гадна талаас хаалга нээх



Хаалганы бариулын **A** хаалга нээх товч дарж хаалга нээнэ.

Хаалганы бариулын дотор талын хаалга нээх **A** товчийг сайтар дарна.

### Дотор талаас хаалга нээх




Хаалга нээх **A** товчны урд талыг дарж хаалга нээнэ.

Жолоочийн хаалга: Хаалга түгжээтэй байсан ч нээгдэнэ.

Хаалганы түгжээ тайлагдах үед хаалганы түгжээний индикатор унтарна.

## Арын хаалганы хүүхэд хамгаалах түгжээ



Тус түгжээг түгжсэн үед хаалга дотор талаас нээгдэхгүй.


**1** Түгжээ тайлах

**2** Түгжих

Тус түгжээг бага насны хүүхэд арын хаалгыг нээхээс сэргийлж түгжих боломжтой. Арын 2 хаалганы түгжээг доош дарж 2 хаалгыг түгжинэ.

# Автомат цонх


## Цонх нээх ба хаах



- 1 Хаах
- 2 Гүйцэд хаах\*
- 3 Нээх
- 4 Гүйцэд нээх\*

\*: Цонхыг дунд нь зогсоохын тулд товчийг эсрэг чиглэлд хөдөлгөнө.

## Санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх (Цонх түгжих товч)



Товчийг дарна.

**A** индикатор асаж зорчигчийн цонх түгжигдэнэ.


Жолоочийн хаалган дахь цонхны товчоор зорчигчийн цонхийг нээх буюу хааж болно.

Тус функц нь бага насны хүүхэд санамсаргүйгээр зорчигчийн цонх ажиллуулахаас сэргийлнэ.

# Дээврийн нээлхий (тоноглогдсон автомашинд)

## Дээврийн нээлхий ажиллуулах

### ■ Нээх ба хаах



#### 1 Дээврийн нээлхий нээх\*


Шууд бүрэн нээгдэхгүй ба бүрэн нээгдэхийн өмнөх байрлалд салхины чимээг бууруулж хагас нээгдэнэ.

Товчийг дахин дарж дээврийн нээлхийг бүрэн нээнэ.

#### 2 Дээврийн нээлхий хаах\*

\*: Дээврийн нээлхийг хагас нээх үед товчны аль нэг талыг дарна.

### ■ Өргөх ба буулгах



#### 1 Дээврийн нээлхий өргөх\*


#### 2 Дээврийн нээлхий буулгах\*

\*: Дээврийн нээлхийг хагас нээх үед товчны аль нэг талыг зөөлөн дарна.

# Панорамик дээврийн нээлхий (тоноглогдсон автомашинд)

## Панорамик дээврийн нээлхий ажиллуулах

### ■ Электрон нарны хаалт нээх ба хаах



#### 1 Электрон нарны хаалт нээх

 товчийг удаан дарсан үед электрон нарны хаалт бүрэн нээгдэнэ.\*<sup>1</sup>


#### 2 Электрон нарны хаалт хаах

 товчийг удаан дарсан үед электрон нарны хаалт бүрэн хаагдана.\*<sup>2</sup>

\*<sup>1</sup>: Ажиллаж буй дээврийн нээлхийг зогсоох үед  товчны аль нэг талыг дарна.

\*<sup>2</sup>: Ажиллаж буй дээврийн нээлхийг зогсоох үед  товчны аль нэг талыг дарна.

### ■ Панорамик дээврийн нээлхийг өргөх ба буулгах



Панорамик дээврийн нээлхий өргөх (дарах)\*


Панорамик дээврийн нээлхий өргөдсөн үед электрон нарны хаалт хагас байрлалд нээгдэнэ.

\*: Панорамик дээврийн нээлхийг хагас нээх үед  товчны аль нэг талыг дарна.

Панорамик дээврийн нээлхий буулгах (удаан дарах)

Панорамик дээврийн нээлхийг зөвхөн дээш өргөгдсөн байрлалаас доош буулгах боломжтой.

## ■ Панорамик дээврийн нээлхий нээх ба хаах



### 1 Панорамик дээврийн нээлхий нээх\*1

Панорамик дээврийн нээлхий ажиллах үед панорамик дээврийн нээлхийн  товчны аль нэг талыг дарж зогсооно.

Дээш өргөсөн байрлалаас панорамик дээврийн нээлхийг нээх боломжтой.

### 2 Панорамик дээврийн нээлхий хаах\*2

Дээш өргөсөн байрлалаас панорамик дээврийн нээлхийг нээх боломжтой.

 товч дарна. Панорамик дээврийн нээлхий автоматаар бүрэн хаагдана.

\*1: Ажиллаж буй электрон нарны хаалтыг зогсоох үед  товчны аль нэг талыг дарна.


\*2: Ажиллаж буй электрон нарны хаалтыг зогсоох үед  товчны аль нэг талыг дарна.

## Шатахууны савны таг

### Шатахуун цэнэглэхийн өмнө


- Бүх хаалга, цонх хааж асаах товчийг OFF горимд унтраана.
- Шатахууны төрлийг нягтална.

### Шатахууны савны таг онгойлгох




- 1 Товч дарж шатахууны савны тагийг онгойлгоно.

БНСУ болон Бразил: Товч дарсны дараа шатахууны савны таг 10 секундийн дотор нээгдэнэ. Шатахуун цэнэглэх боломжтой болсныг илтгэж хянах самбар дахь мэдээллийн дэлгэц дээр шатахууны савны таг нээгдэх явцыг харуулна.



- 2 Шатахууны савны тагийг зөөлөн эргүүлэн нээж тусгай сууринд байрлуулна.

### Шатахууны савны таг хаах




Шатахуун цэнэглэж дууссаны дараа тагийг чаг хийж дуугарах хүртэл эргүүлнэ. Тагнаас гараа авах үед таг эсрэг чиглэлд бага зэрэг буцна.

# Тээшний автомат хаалга

## Тээшний автомат хаалга нээх/хаах

### ■ Тээшний хаалга дотор талаас нээх, хаах



Товчийг 1 секунд орчим удаан дарна.

Дохио дуугарч тээшний автомат хаалга автоматаар нээгдэх буюу хаагдана. Нөгөөтээгүүр тээшний автомат хаалга түгжээтэй үед нээгдэхгүй.

Тээшний автомат хаалга нээгдэж/хаагдаж байгаа үед товч дарвал хаалганы ажиллагаа зогсоно.

Товчийг дахин 1 секунд орчим удаан дарсан үед тээшний автомат хаалга эсрэг чиглэлд ажиллана.

### ■ Тээшний хаалга гадна талаас нээх, хаах

► Smart Entry & Start систем


→ Р. 24

► Түлхүүрийн алсын удирдлага

→ Р.22

► Тээшний хаалга нээх товч

● Нээх



Тээшний автомат хаалганы түгжээ тайлагдсан үед: Тээшний хаалга нээх товч дарна.


Тээшний автомат хаалга түгжээтэй үед:

Биедээ электрон түлхүүр авч тээшний хаалга нээх товч удаан дарна.

Дохио дуугарч тээшний автомат хаалга автоматаар нээгдэнэ.

Тээшний автомат хаалга нээгдэж/хаагдаж байгаа үед товч дарсан нөхцөлд хаалга зогсоно.

## ● Хаах




 товч дарна.

Дохио дуугарч тээшний автомат хаалга автоматаар хаагдана.

Тээшний автомат хаалга хаагдах үед

 товч дарсан нөхцөлд хаалга зогсоно. Товч дахин дарах үед тээшний автомат хаалга автоматаар нээгдэнэ.

- Тээшний хаалгыг хаагаад хаалганаас холдсоны дараа бүх хаалга түгжих (хаагаад түгжих [хаалганаас холдох] функц)



- 1 Электрон түлхүүртэй үедээ тээшний хаалганаас бусад бүх хаалгыг хаагаад тээшний хаалганы доод хэсэгт байрлах  товчийг дарна.

Дохио хэвийн үеэс өөрөөр дуугарах ба хаагаад түгжих (хаалганаас холдох) функц хүлээлгийн горимд орно.

- 2 Дохио дуугарах үед тээшний хаалганаас холдоно.

Мэдрэгч таныг тээшний хаалганаас холдсоныг мэдэрсэн үед ослын дохионы гэрэл анивчиж (зарим загварт) дохио дуугарна. Тээшний хаалганаас холдсон чиглэл, байрлал болон электрон түлхүүр хэрхэн барьж байгаа мөн зарим байдлаас хамаарч зөв танихгүй байж болно.

Тээшний хаалганаас бусад бүх хаалга түгжигдэх ба тээшний хаалга мөн түгжигдэнэ. Бүх хаалга хаагдаж түгжигдсэн үед дохио (тоноглогдсон автомашинд) дуугарч ослын дохионы гэрэл анивчина.


Тээшний хаалганаас 30 секундийн дотор холдоогүй үед тус функцийн хүлээлгийн горим цуцлагдана. Функцийг дахин ажиллуулах үед үйлдлийг дахин эхнээс нь хийнэ.

Хэрэв тээшний хаалганд электрон түлхүүртэй дахин ойртсон үед хаалганы ажиллагаа зогсох ба бүх хаалганы түгжээ тайлагдаж дохио (тоноглогдсон автомашинд) дуугарч ослын дохионы гэрэл анивчина.

Тээшний хаалганы ажиллагаа зогссоны дараа  товч дарсан үед хаагаад түгжих (хаалганаас холдох) функц дахин хүлээлгийн горимд орно.

- Тээшний хаалгыг хаасны дараа бүх хаалга түгжих (хаагаад түгжих функц)\*

\*: Тус тохиргоог та өөрийн Lexus дилер дээр хийлгэх боломжтой.



 товч дарна.

Тээшний автомат хаалга хаагдаж бүх хаалга зэрэг түгжигдэнэ.

Дохио хэвийн үеэс өөрөөр дуугарч тээшний автомат хаалга автоматаар хаагдаж эхэлнэ. Тээшний автомат хаалга хаагдах үед бүх хаалга зэрэг түгжигдэх ба ажиллагааны дохио асаж хаалга түгжигдсэнийг илтгэнэ.


Тээшний автомат хаалга хаагдах үед

 товч дарсан нөхцөлд ажиллагаа зогсоно.

Товч дахин дарах үед тээшний автомат хаалга автоматаар нээгдэнэ.

Давхар цоожлох системтэй автомашин: Энэ үед давхар цоожлох систем ажиллахгүй.

## ■ Гарын оролцоогүй тээшний автомат хаалга (тоноглогдсон автомашинд)




- 1 Электрон түлхүүр биедээ авч Smart Entry & Start системийн ажиллагааны хүрээ болох арын гупернээс 50-с 60см (19.7-с 23.6 ич) зайд зогсоно.

**A** Хөлөөр ажиллуулах мэдрэгч

**B** Гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагааны мэдрэх хүрээ

**C** Smart Entry & Start системийн ажиллагааны мэдрэх хүрээ



**2** Арын гупернээс 10 см (3.9 инч) зайд хөлөө оруулаад дохио дуугарсны дараа гаргана.

- Бүх үйлдлийг 1 секундэд хийнэ.
- Арын гуперны доор хөл мэдэрсэн үед гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллахгүй.
- Арын гуперт хөлөөр хүрэлгүйгээр гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллуулна.
- Бүхээг эсвэл тээшний хэсэгт өөр электрон түлхүүр байгаа үед хаалга ажиллаж эхлэхэд бага зэрэг удаан байж болно.
- Дуут дохио 2 удаа дуугарсан үед үйлдлийг давтана.

**A** Хөлөөр ажиллуулах мэдрэгч

**B** Гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллах хүрээ


**3** Хөлөөр ажиллуулах мэдрэгч гуперны доор хөл ороод гарсныг мэдрэх үед дуут дохио дуугарах ба тээшний хаалга автоматаар нээгдэх буюу хаагдана.

Тээшний хаалга ажиллах явцад дахин хөлөө гупер доогуур оруулсан үед хаалганы ажиллагаа зогсоно.

**■ Хөлөөр ажиллуулах мэдрэгч (Гарын оролцоогүй хаагаад түгжих [Хаалганаас холдох] функц) \*1, 2 ашиглан тээшний хаалга хаагаад холдох үйлдлээр түгжих**

\*1: Тоноглогдсон автомашинд

\*2: Тус тохиргоог та өөрийн Lexus дилер дээр хийлгэх боломжтой.




**1** Электрон түлхүүр биедээ авч Smart Entry & Start системийн ажиллагааны хүрээ болох арын гупернээс 50-с 60см (19.7-с 23.6 ич) зайд зогсоно.

**A** Хөлөөр ажиллуулах мэдрэгч

**B** Гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагааны мэдрэх хүрээ

**C** Smart Entry & Start системийн ажиллагааны мэдрэх хүрээ



**2** Арын гупернээс 10 см (3.9 инч) зайд хөлөө оруулаад дохио дуугарсны дараа гаргана.

- Бүх үйлдлийг 1 секундэд хийнэ.
- Арын гуперны доор хөл мэдэрсэн үед гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллахгүй.
- Арын гуперт хөлөөр хүрэлгүйгээр гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллуулна.
- Бүхээг эсвэл тээшний хэсэгт өөр электрон түлхүүр байгаа үед хаалга ажиллаж эхлэхэд бага зэрэг удаан байж болно.
- Дуут дохио 2 удаа дуугарсан үед үйлдлийг давтана.

**A** Хөлөөр ажиллуулах мэдрэгч

**B** Гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагааны мэдрэх хүрээ

**3** Арын гупернээс хөлөө буцааж гаргасныг хөлөөр ажиллуулах мэдрэгч мэдэрсэн үед хэвийн үеэс дохио өөрөөр дуугарч гарын оролцоогүй хаагаад түгжих (хаагаад холдох) функц хүлээлгийн горимд шилжинэ.

#### 4 Дохио дуугарах үед тээшний хаалганаас холдоно.

Мэдрэгч хаалганаас холдсоныг мэдэрсэн үед ослын дохионы гэрэл анивчиж (зарим загварт) дохио дуугарна. Тээшний хаалганаас холдсон чиглэл, байрлал болон электрон түлхүүр хэрхэн барьж байгаа мөн зарим нэг байдлаас хамаарч зөв танихгүй байж болно.

Тээшний хаалганаас бусад бүх хаалга түгжигдэх ба тээшний хаалга мөн түгжигдэнэ. Бүх хаалга хаагдаж түгжигдсэн үед дохио (тоноглогдсон автомашинд) дуугарч ослын дохионы гэрэл анивчина.

Тээшний хаалганаас 30 секундийн дотор холдоогүй үед функцийн хүлээлгийн горим цуцлагдана. Дахин ажиллуулах үед үйлдлийг дахина.

Хэрэв тээшний хаалганд электрон түлхүүртэй дахин ойртсон үед хаалганы ажиллагаа зогсох ба бүх хаалганы түгжээ тайлагдаж дохио (тоноглогдсон автомашинд) дуугарч ослын дохионы гэрэл анивчина.

Тээшний хаалганы ажиллагаа зогссоны дараа тээшний автомат хаалга ажиллуулсан үед гарын оролдоогүй хаагаад түгжих (хаагаад холдох) функц дахин хүлээлгийн горимд шилжинэ.

## Анхааруулах гэрэл, индикаторын жагсаалт

Даруй аюулгүй газар автомашинаа зогсоож Lexus дилертээ хандана уу. Үргэлжлүүлэн жолоодох нь аюултай байж болно.



(Улаан)

Тоормосны системийн  
анхааруулах гэрэл

Даруй аюулгүй газар автомашинаа зогсоож Lexus дилертээ хандана уу.



Аккумулятор цэнэглэх  
системийн анхааруулах  
гэрэл



Доголдол анхааруулах гэрэл



Хөдөлгүүрийн тосны даралт  
багассаныг анхааруулах  
гэрэл

Даруй өөрийн Lexus дилер дээр оношилгоо хийлгэнэ үү.



(Шар)

Тоормосны системийн  
анхааруулах гэрэл



Lexus parking assist-sensor  
OFF индикатор



SRS анхааруулах гэрэл



(Асах)

Шарвалтын индикатор



ABS анхааруулах гэрэл



(Анивчих)

Зогсоолын тоормосны  
индикатор



(Улаан эсвэл  
шар)

Электрон жолооны  
системийн анхааруулах  
гэрэл



(Анивчих)

Тоормос баригчийн  
ажиллагааны индикатор



(Анивчаад  
үргэлжлэн  
асах)

Дугуйн даралт анхааруулах  
гэрэл

Дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.

## Засах үйлдлийг хийнэ.



Дөрөөний буруу ажиллагааг анхааруулах гэрэл



Шатахуун багассаныг анхааруулах гэрэл



Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүсний гэрэл



(HUD дэлгэцгүй автомашин)

Арын зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл



(HUD дэлгэцтэй автомашин)



(Анивчилгүй-гээр асна)

Дугуйн даралт анхааруулах

гэрэл\*



Lexus parking assist-sensor OFF индикатор



PCS анхааруулах гэрэл (тоноглогдсон автомашинд)



(Шаргал)

LTA индикатор (тоноглогдсон автомашинд)



(Шаргал)

LDA индикатор (тоноглогдсон автомашинд)



(Шаргал)

Динамик радарын хурд баригчийн индикатор (тоноглогдсон автомашинд)



(Шаргал)

Хурд баригчийн индикатор



(Шаргал)

PDA индикатор (тоноглогдсон автомашинд)



Жолоодлогод туслах мэдээллийн индикатор



(Анивчих)

Зогсоолын тоормосны индикатор

## Зогсоод шалгана.



Хөргөлтийн шингэний хэм анхааруулах гэрэл



Хайбрид системийн хэт халалт анхааруулах гэрэл

Дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.

“Хэрэглэгчийн гарын авлага” уншина уу.



Эргэх дохионы индикатор



LTA индикатор  
(Тоноглогдсон автомашинд)



Оврын гэрлийн индикатор



BSM хажуугийн толины  
индикатор (тоноглогдсон  
автомашинд)



Холын гэрлийн индикатор



Lexus parking assist-sensor  
OFF индикатор



AHS индикатор  
(тоноглогдсон автомашинд)  
AHB индикатор  
(тоноглогдсон автомашинд)



Жолоодлогод туслах  
мэдээллийн индикатор



Урд манангийн гэрлийн  
индикатор



Шарвалтын индикатор



Хойд манангийн гэрлийн  
индикатор  
(тоноглогдсон автомашинд)



VSC OFF индикатор



PCS анхааруулах гэрэл  
(тоноглогдсон автомашинд)



“READY” индикатор



Хурд баригчийн индикатор



Зогсоолын тоормосны  
индикатор



Динамик радарын хурд  
баригчийн индикатор  
(тоноглогдсон автомашинд)



Тоормос баригчийн  
хүлээлгийн горимын  
индикатор



LDA индикатор  
(тоноглогдсон автомашинд)



Тоормос баригчийн  
ажиллагааны индикатор



LDA OFF индикатор  
(тоноглогдсон автомашинд)



Дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.

Энэ үед яах вэ...

**“Хэрэглэгчийн гарын авлага” уншина уу.**



EV индикатор



PDA индикатор  
(тоноглогдсон автомашинд)



Хэт хүйтэн агаарын хэмийн  
индикатор



Тоормосны гэрлийн  
индикатор



“PASSENGER AIR  
BAG” индикатор  
(тоноглогдсон  
автомашинд)

● Жолоодлогын горимын индикатор



EV жолоодлогын горимын  
индикатор (зөвхөн RX350h)



Customize горимын  
индикатор



Эко жолоодлогын горимын  
индикатор



Trail Mode индикатор  
(тоноглогдсон автомашинд)



Sport горимын индикатор


**Дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.**

\*: Температурын өөрчлөлт зэргээс шалтгаалан дугуйн хий өөрөө гарах зэргээс шалтгаалж дугуйн хийн даралт анхааруулах гэрэл асаж болно. Энэ тохиолдолд дугуйн хийн даралтыг тохируулсны дараа гэрэл унтарна (тодорхой хэдэн минутын дараа). Дугуйны хийн даралт тохируулсан ч гэрэл унтрахгүй байвал та өөрийн Lexus дилерт хандаж системийг оношлуулна уу.

## Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед


### Хаалга түгжих, тайлах

Механик түлхүүр ашиглах үед дараах үйлдлийг хийнэ:




- 1 Хуванцар карт зэргийг хаалганы бариулын завсар хийж тагийг салгана.

Гэмтээхээс сэргийлж тагийг хэт хүчтэй хөшиж болохгүй.



- 2 Хойд талд нь даран тагийг салгаж авна.




- 3 Механик түлхүүр ашиглах үед дараах үйлдлийг хийнэ:

- 1 Бүх хаалга тайлна

Зарим загварт: Түлхүүрийг арагш эргүүлэх үед жолоочийн хаалга тайлагдана. Дахин эргүүлэхэд бусад хаалга тайлагдана.

- 2 Бүх хаалга түгжинэ

## Хайбрид систем асаах



1 Араа Р байрлалд байгаа эсэхийг шалгаад тоормосны дөрөө гишгэнэ.

2 Асаах товчинд электрон түлхүүрийн Lexus эмблемтэй талыг хүргэнэ.

Электрон түлхүүр танигдах үед анхааруулах дохио дуугарах ба асаах товч ON горимд шилжинэ.

Хэрэглэгчийн хүсэлтээр хийх тохиргоогоор Smart entry & start систем салгагдсан үед асаах товч ACC горимд шилжинэ.

3 Тоормосны дөрөөг сайтар гишгэх ба мэдээллийн дэлгэц дээр  гарч байгааг нягтална.

4 Асаах товчийг богино, чанга дарна.

Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч хайбрид систем асахгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу

Электрон түлхүүрийн зайны цэнэг суусан үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна. Түлхүүрийн зайг шинээр солино. Зай солих тухай дэлгэрэнгүйг “Хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу. Танд нэмэлт мэдээлэл, тусламж хэрэгтэй үед өөрийн Lexus дилерт хандана уу.

Энэ үед яах вэ...

## Хайбрид систем асахгүй үед

Үйлдлийг зөв дарааллын дагуу хийж гүйцэтгэнэ.

Тоормосны дөрөө

Хайбрид систем асаах оролдлого хийх үед тоормосны дөрөөг сайтар гишгэнэ.  
(→Р. 25)

Зөв дарааллаар үйлдлийг хийсэн ч хайбрид систем асахгүй үед “Хэрэглэгчийн гарын авлага”-с дэлгэрэнгүй мэдээлэл харах эсвэл өөрийн Lexus дилертээ хандана уу.


Энэ үед яах вэ...

## Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед

Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед гар аргаар нээх бариул ашиглан нээх боломжтой.

### Гар аргаар нээх бариул ашиглан нээх

#### ■ Гар аргаар нээх бариул ашиглан гадна талаас хаалга нээх




Гар аргаар нээх **A** бариулыг татан хаалга нээнэ.

Хэвийн үед гар аргаар нээх бариул ашиглан хаалга нээх боломжгүй.

Хаалга нээх үед гар аргаар хаалга нээх бариулын ажиллагааг идэвхжүүлнэ.

#### ■ Гар аргаар нээх бариул ашиглан дотор талаас хаалга нээх






Гар аргаар нээх **A** бариулыг 2 удаа татан хаалга нээнэ.

Бариулыг 1 удаа татахад бариулын ажиллагаа идэвхжинэ. Бариулыг дахин татаж хаалга нээнэ.

Энэ үед яах вэ...

## ■ Механик түлхүүр ашиглан гар аргаар нээх гадна бариулын ажиллагааг идэвхжүүлэх



Механик түлхүүр ашиглан гар аргаар нээх гадна бариулын ажиллагааг идэвхжүүлэх боломжтой.

- 1 Хуванцар карт зэргийг хаалганы бариулын завсар хийж тагийг салгана.

Гэмтээхээс сэргийлж тагийг хэт хүчтэй хөшиж болохгүй.

- 2 Хойд талд нь даран тагийг салган авна.

- 3 Механик түлхүүр ашиглан цоожны цилиндрийг түгжээ тайлах чиглэлд эргүүлэн гар аргаар нээх бариулын ажиллагааг идэвхжүүлнэ.

Механик түлхүүр нь нэг талдаа ховилтой тул түлхүүрийг зөвхөн нэг талаар нь хийж болно.

Түлхүүр цоожны цилиндрт орохгүй байгаа үед эргүүлээд дахин хийнэ.

## Тэмдэглэл



## Тэмдэглэл



©2022 ТООТОТА МОТОР КОРПОРАЦ

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Тус материалыг Тоёота Мотор Корпорацийн бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлах, ашиглахыг хориглоно.